




АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧ БОЛОН НИСЭХ БУУДЛУУДАД

/Хаврын улирлын цаг агаарын зөвлөмж/

Манай орны цаг агаар хамгийн их хувьсамтгай үе нь хаврын улирал байдаг. Хаврын улиралд дундад өргөргийн Өндрийн фронтын бүс /ӨФБ/ урдаас хойшлон манай орны нутаг дэвсгэр дээгүүр дамнан байрлах тул фронтын гаралтай циклоны эрчимшил, давтагдал ихсэж цаг агаарын нөхцөл эрс тэс тогтворгүй болдог. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас агаарын температур 1.12°C дулаарсан, хур тунадасны хувьд бараг өөрчлөлтгүй байна.



Их хэмжээний цас орох, үүнтэй холбоотойгоор нам үүл ажиглагдах, борооны бөөн үүл хөгжих зэргээс мөстөлт ажиглагддаг бол, салхины улмаас ихээхэн хэмжээний газар нутгийг хамарсан цасан болон шороон шуурга шуурч алсын барааны харагдац муудах, нислэгийн замд сэгсрэлт, мөстөлт үүсэх, шар усны үер болох, хуурайшилт нэмэгдсэнээр ой хээрийн түймэр гарах зэрэг цаг агаарын аюултай үзэгдлүүд ажиглагддаг.

Дэлхийн цаг уурын байгууллагын зөвлөмжид аливаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд аюул учруулж болох нөлөөллийг нь харгалзан 15м/с ба түүнээс дээш салхийг хүчтэйд тооцдог. Харин нисэх буудал, агаарын хөлгийн төрлөөс хамаарч хөөрч буух үеийн арын ба хөндлөнгийн салхины тогтоосон хязгаарлалтууд өөр өөр байдаг бөгөөд түүнээс давсан салхийг хүчтэйд тооцдог. Хүчтэй салхины 50% гаруй нь III- V сард, 60% орчим нь III – VI сард тохиолдоно. Хүчтэй салхины хоногийн явцаас үзэхэд 20% гаруй нь 12-15 цагийн хооронд, 10% орчим нь 18 - 21 цагт, харин 3 - 6 цагийн хооронд дөнгөж 5% орчим нь ажиглагддаг. Хүчтэй салхины үргэлжлэх хугацаа ихэнх нутагт 1-6 цаг байдаг. Монгол орны нутаг дэвсгэрийн 30%-иас их нутгийг хамарсан хүчтэй салхи ажиглагдсан өдрийн тоог 2002-2022 оны мэдээгээр өсөлттэй гарсан байна.




Хүчтэй салхитай холбоотойгоор цасан шуурганы давтагдал ихэсдэг, мөн үзэгдэх орчин хязгаарлагдан алсын барааны харагдац муутгадаг ба нийт тохиолдлын 65% нь 2 км-ээс, 50% орчим нь 1км-ээс бага байна. Цас орж цасан шуурга шуурах /орон шуурга/ нь ихэвчлэн III-V сард тохиолдох ба говь тал нутгаар III сард, уулархаг нутаг болон Их нууруудын хотгорт IV сард хамгийн олон тохиолдоно. Орон шуургатай өдрийн газарзүйн тархацыг авч үзвэл Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Дундговь аймгийн нутгаар жилд 5 хоногоос, зүүн аймгуудын нутгаар 6 хоногоос, Алтай орчим 9 хоногоос их байдаг.


Цас орж цасан шуурга шуурахыг орон шуурга гэх бөгөөд орон шуурганы тасралтгүй үргэлжлэх хугацааны 30-40% нь 1.1 - 3.0 цаг ажиглагддаг, 30 минутаас богино юм уу 12 цагаас удаан үргэлжилсэн орон шуурга цөөн тохиолдоно. Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар жилд 5 өдрөөс цөөн, Их нууруудын хотгорт 10-17, говийн бүсэд 20-37 өдөр байдаг.

Шороон шуурганы давтагдлын 60% орчим нь энэ улиралд ажиглагдана. Хангайн бүс нутаг, Их нууруудын хотгорт шороон шуурганы 60-80% нь 3 цагаас богино хугацаагаар үргэлжилдэг бол тал хээр, говийн бүсэд 12 цагаас давах тохиолдол цөөнгүй байдаг. Цаг уурын ажиглалтын 68 станцын 1981-2021 оны 4 дүгээр сард ажиглагдсан явган болон шороон шуургатай өдрийн сүүлийн 40 жилийн өөрчлөлтийг 2 үеэр (1982-2001, 2002-2021) тооцон үзэхэд эхний 20 жилд явган шороон шуургатай өдрийн тооны давтагдал баруун бүсэд харьцангуй их (3-15), говийн бүсэд харьцангуй бага (1-10), шороон шуургатай өдрийн тоо говь болон төвийн бүс нутгаар харьцангуй их (3-10), бусад нутгаар жигд тархалттай байна, харин сүүлийн 20 жилд явган шороон шуурга болон шороон шуургатай өдрийн тоо бүх нутгаар илэрхий нэмэгдсэн, ялангуяа төв болон говийн бүсэд шороон шуургатай өдрийн тоо 2 дахин нэмэгдсэн байна.

4 дүгээр сард ажиглагдсан явган шороон шүүргатай өдрийн тоо



4 дүгээр сард ажиглагдсан шороон шүүргатай өдрийн тоо



ӨФБ манай орны нутаг дэвсгэр дээгүүр дамнан байрладгаас тропосферын дунд болон дээд хэсэгт дэлхийн гадаргаас 5-10 км-ийн өндөрт судал урсгал ажиглагддаг ба салхины хурд бусад улиралтай харьцуулахад огцом ихэсдэг. Үүнтэй холбоотойгоор бүх түвшинд салхины хурд болон чиглэлийн өөрчлөлт болж салхины шилжлэг ажиглагддаг. Салхины шилжлэг ажиглагдаж буй бүсэд агаарын хөлөг нислэг үйлдэхэд сэгсрэлтэд ордог.

Шар усны үер нь хаврын улиралд дулаарч агаарын температур нэмэгдэхийн хэрээр өвөл хөрлөсөн цас хайлахад уулархаг нутгаар голчлон тохиолдоно. Шар усны үер нь Монгол Алтайн нурууны голуудад үндсэндээ 4 дүгээр сарын дундуур, харин ус хурах талбай нь нэлээд өндөрт орших голын хаврын шар усны үер арай хожуу 4 дүгээр сарын сүүлч, 5 дугаар сарын дундуур эхэлнэ. Хөвсгөлийн уулс, Хангай, Хэнтэй нуруунаас эх авсан гол мөрөнд хаврын шар усны үер голын адгаар 4 дүгээр сарын эхний 10 хоногт, ус хурах талбайн ихэнх нь 2500 м-ээс дээш өндөрт хамрагдаж байвал 5 дугаар сарын эхний 10 хоногт ажиглагдана. Хаврын шар усны үерийн хамгийн их хэмжээ 1500 м-ээс доош өндөр бүхий ус хурах талбайтай голуудад мөн сарын хоёрдугаар арван хоногт тохиолдоно. Зөвхөн Монгол Алтайн нурууны голуудад хаврын шар усны үерийн хамгийн их хэмжээ арай хожуу, 6 дугаар сарын сүүлчээр ажиглагдана.

Хаврын улиралд хуурайшилт, салхи шуурга ихсэхтэй холбоотойгоор ой хээрийн түймэр гарах тохиолдол ихэсдэг. Нийт түймрийн 90% гаруй нь хүний анхаарал болгоомжгүй байдлаас үүсэлтэй хэдий ч гарсан түймрийг илүү их аюултай болгодог нь цаг агаарын нөхцөл байдаг. Тал хээрийн өвс ургамлын хуурайшилтад хүчтэй салхины нөлөөлөл байдаг ба хээрийн түймэр нь ургамал, амьтан төдийгүй хүн ам эдийн засагт ихээхэн хүнд хохирол учруулдаг аюултай байгалийн үзэгдэл юм.



Иймд шилжилтийн улирал эхэлж байгаатай холбогдуулан тухай бүр цаг агаарын урьдчилсан мэдээтэй танилцаж үйл ажиллагаагаа цаг агаарын нөхцөл байдалд уялдуулан, мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч зохион байгуулах талаар арга хэмжээ авч ажиллана уу. Цаг агаарын урьдчилсан мэдээ, бодит ажиглалтын мэдээ, цаг уурын радарын мэдээ, хиймэл дагуулын зургийг дараах хаягаар орж авна уу.

1. <http://amc.namem.gov.mn/>
2. <https://weather.gov.mn/>
3. <https://irimhe.namem.gov.mn/>
4. <http://icc.mn/>

Энэхүү зөвлөмжид Цаг уурын станцуудын мэдээ мэдээлэл, графикыг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын судалгааны ажлаас авч ашигласан болно.

Нислэгийн Цаг Уурын Төв